

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН МЭДЭЭ (2023 оны 01 дүгээр улирлын байдлаар)

2023 оны 03 дугаар сарын 20

Улаанбаатар хот

Тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/1049 дугаар захирамжаар батлагдсан “Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу шийдвэрлэн ажиллаж байна.

Нэг. Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн мэдээ

Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдаас нийт 56 өргөдөл ирснийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем /<https://erp.ulaanbaatar.mn> /-д бүртгэн, 47 өргөдлийг бүрэн шийдвэрлэж хариуг өргөдөл гаргагчид танилцуулсан бол 9 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна. Өргөдөл гомдлын бүртгэл, явц болон шийдвэрлэлттэй холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй болно. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 13 цаг 57 минут байна.

Хоёр. Өргөдөл, гомдлын хандалтын мэдээ (өссөн дүнгээр)

2023 оны жилийн 1 дүгээр улирлын байдлаар байгууллагад ирсэн өргөдлийн хандалтыг төрлөөр нь ангилбал:

- Ажлын сахилга, хариуцлагын тухай-1
- Ажилд шилжин, дэвшин ажиллах тухай өргөдөл-1
- Нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай (иргэнээс)-1
- Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл– 4
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл– 8
- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл- 9
- Захиргааны чөлөө хүссэн өргөдөл–13
- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл- 18

Өргөдөл гомдлын төрлийг нийт өргөдөлд эзэлж буй хувиар нь үзүүлбэл:



График 1. Өргөдлийг төрлөөр нь ангилсан байдал.

Гурав. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг өмнөх үетэй харьцуулсан байдал

Хүснэгт1

Д/д	Хугацаа	2022.01 улирал	2023.01 улирал
Ерөнхий үзүүлэлт			
1	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	7 хоног 2 цаг 58 минут	6 хоног 6 цаг 0 минут
2	Хандалтын тоо	42	55
3	Зөрчлийн үзүүлэлт	2	0
Өргөдөл гомдлын хандалтын төрөл			
4	Иргэнээс гаргасан санал, хүсэлт	0	1
5	Ажлын сахилга, хариуцлагын тухай	0	1
6	Ажилд шилжин, дэвшин ажиллах тухай өргөдөл	0	1
7	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл	3	8
8	Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл	8	4
9	Захиргааны чөлөө хүссэн өргөдөл	7	13
10	Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл	15	18
11	Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл	8	9

Дүгнэлт:

Графикаас харахад газрын хэмжээнд 2023 оны 1 дүгээр улиралд ирсэн нийт өргөдлийн тоо 0,3%-иар өссөн ч шийдвэрлэлтийн дундаж хугацаа 1 хоногоор буурсан байна.


Ажилтан, албан хаагчдаас ирсэн өргөдөл, гомдлыг тухай бүр дотоод удирдлагын /<https://erp.ulaanbaatar.mn/> бүртгэлийн системд байршуулан технологийн шийдэл ашиглан, шийдвэрлэлтийн явцыг ил тод, шуурхай байлгах зорилгоор явцын тэмдэглэлийг 10 хоног тутамд хөтлөн, 2 удаагийн шат дамжлагатайгаар шийдвэрлэн ажиллаж байна.

ТАЙЛАН ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН



Т.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ӨГӨДӨЛ ГОМДОЛ ХАРИУЦСАН
АЖИЛТАН



А.НОМИНЗУЛ